

БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРМИЙН ХЭЛЭЛЦЭЭ: БНСУ-МОНГОЛ УЛС ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ө. Номинцэцэг*, Н. Отгонсайхан**, Э. Дэлгэржаргал***

Хураангуй. Орчин үеийн дэлхийн худалдааны систем болон бүс нутгийн хэлэлцээрүүдэд гарал үүслийн дүрэм (ГҮД)-ийн хэрэглээ нь хамгийн чухал асуудлуудын нэг болоод байна. ГҮД-ийг бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдэд үр дүнтэй, зөв хэрэгжүүлэн мөрдсөнөөр гишүүн орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх эдийн засгийн ач холбогдлыг нэмэгдүүлдэг. Гэвч бүс нутгийн хэлэлцээрүүд улам нэмэгдэхийн хэрээр олон янзын ГҮД хэрэглэгдэж байгаа нь Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)-ын гишүүд болон хувийн хэвслийнхэнд томоохон сорилтыг дагуулж байна. МУ, БНСУ хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах хэлэлцээний үе шат эхэлсэн бөгөөд ГҮД-ийн хэлэлцээ хийхэд зайлшгүй анхаарах асуудлууд байдаг. Тиймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд тус улстай хэлэлцээр байгуулах нөхцөлд ГҮД-ийн талаар анхаарах асуудлыг тус улстай хэлэлцээр байгуулсан улсуудын туршлагыг харьцуулах, мөн өмнө судлагдсан эрдэмтдийн бүтээлүүд дээр тулгуурлан судаллаа.

Түхүүр үгс: Хөнгөлөлттэй ГҮД, эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр, экспортын потенциал, дотоодын эмзэг салбарын ГҮД, ГҮД-ийн хэрэглээний сайн туршлага

NEGOTIATING THE RULES OF ORIGIN: SOME ISSUES CONCERNING THE ECONOMIC PARTNERSHIP AGREEMENT BETWEEN MONGOLIA AND KOREA

Abstract. The application of Rules of origin (RoO) has become one of the most important issues in the modern global trading system and regional agreements. The effective and proper implementation and enforcement of RoO in regional trading agreements improves the economic importance of increasing trade and investment among member countries. However, the growing number of regional preferential agreements and their application of diverse RoO pose significant challenges for the WTO members and the private sector. In the case of Mongolia, the negotiation stage of establishing an Agreement on the economic partnership with the Republic of Korea has begun, and attention should be paid to negotiations on the RoO. Therefore, in the framework of this research, the issues to be considered regarding the RoO in the context of negotiating with the country have been studied based on the comparison of the experience of the country with the country, as well as previous studies.

Key words: Preferential RoO, Economic Partnership Agreement, Export potential, sensitive products' RoO, best practices on the application of RoO

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): nomintsetseg@num.edu.mn

** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): otgonsaikhan@num.edu.mn

*** МУИС, Бизнесийн сургууль, (E-mail): 22m1num0060@stud.num.edu.mn

УДИРТГАЛ ХЭСЭГ

Орчин үеийн дэлхийн худалдааны систем болон бүс нутгийн хэлэлцээрт гарал үүслийн дүрэм (ГҮД) нь хамгийн чухал асуудлын нэг болоод байна. Гарал үүслийн хөнгөлөлттэй бус дүрмийг уялдуулах хэлэлцээнүүд тасралтгүй хийгдэж байгаа хэдий ч бүс нутгийн хөнгөлөлттэй хэлэлцээрүүдийн өргөжилтөөс улбаалан гаалийн татварын орлого бүрдэлтийн асуудал анхаарлын төвд хэвээр байна.

ГҮД-ийг бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдэд үр дүнтэй, зөв хэрэгжүүлж, мөрдсөнөөр гишүүн орнуудын худалдаа, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд түлхэц үзүүлдэг. Гэсэн хэдий ч бүс нутгийн хөнгөлөлттэй хэлэлцээрүүд улам бүр нэмэгдэж¹, эдгээрт олон янзын ГҮД хэрэглэгдэж байгаа нь Дэлхийн гаалийн байгууллага (ДГБ)—ын гишүүд болон хувийн хэвшлийнхэнд томоохон сорилтыг дагуулж байна. ГҮД-ийг хэрэглэхэд аливаа захиргааны шинж чанартай саад тотгорыг олон улсын худалдаанд оролцогсдод хийгээд хил, гаалийн байгууллагад нэмж үүсгэхгүй байх шаардлагатай бөгөөд харин аль болох гарал үүслийн дүрмүүдийг хялбаршуулан илүү хөнгөвчлөх арга замыг эрэлхийлэх нь зүйтэй хэмээн ДГБ—аас удирдлага болгодог.

Монгол улсын хувьд бүс нутгийн хэлэлцээрт нэгдэн орох үйл явцтай хөл нийлүүлэн 2016 онд Япон улстай анхны ЭЗТХ—ийг хэрэгжүүлж эхэлснээс хойш даруй 7 жил гаруйн хугацаа өнгөрчээ. Бүс нутгийн эдийн засгуудтай дараа дараагийн түншлэлийн хэлэлцээрийг байгуулах асуудлаар тасралтгүй яриа, хэлэлцээг талуудтай хийж байгаа бөгөөд үүнд БНСУ—тай байгуулах ЭЗТХ—ийн хамтарсан судалгааг мөн хийж гүйцэтгэжээ.

ЭЗТХ—ийг тус улстай байгуулахад ГҮД-ийг зөв, ойлгомжтой, тодорхой мөн гадаад худалдаанд саад учруулахгүй байхуйц тохирох нь манай улсын эдийн засагт ихээхэн ач холбогдолтой учраас энэхүү судалгааг хийхийг зорьлоо.

Тус судалгааны ажил нь дараах бүтэцтэй. Үүнд: Удиртгал хэсэг, сэдвийн судлагдсан байдал, мөн үндсэн судалгааны 4 хэсэгтэй: (1) МУ—ын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээгдэхүүний ГҮД—ийн талаарх судалгаа; (2) Дотоодын эмзэг бүтээгдэхүүний ГҮД—ийн хэлэлцээний хувьд анхаарах асуудал; (3) Салбарын ГҮД—ийн хэлэлцээнд анхаарах асуудлын тухай судалгаа; мөн (4) ГҮД—ийн хэрэглээний олон улсын сайн туршлагад дүн шинжилгээ хийх. Эцэст нь судалгааны дүгнэлт, саналаа тусгалаа.

¹ 2023 оны байдлаар Дэлхийн худалдааны байгууллагад бүртгэгдсэн нийт 589 хэлэлцээр, хүчин төгөлдөр хэрэгжиж буй 355 хэлэлцээр байна.

СЭДВИЙН СУДЛАГДСАН БАЙДАЛ

ГҮД-ийн талаарх олон эрдэмтдийн судалгаанд тухайлбал, судлаач Krueger (1999)-ийн судалгаанд ГҮД нь өөрөө худалдааны нуугдмал саад тотгор (a hidden trade barrier) үүсгэдэг бөгөөд энэ нь цаашлаад худалдааны хазайлт (trade diversion)-ын нөлөөг бий болгоход нөлөөлдгийг тогтоожээ. Тэрээр Хойд Америкийн чөлөөт худалдааны хэлэлцээр (NAFTA)-ийн жишээн дээр судалсан бөгөөд АНУ-руу бараа, үйлчилгээ экспортлодог Мексикийн компаниуд ГҮД-ийн шалгуураа хангахын тулд өндөр өртөгтэй түүхий эд, материалыг АНУ-аас импортлож байсан явдал нь АНУ түүхий эдийн үйлдвэрлэлээ бодлогын өндөр түвшинд хамгаалж буй хэрэг гэдгийг нь харуулсан байна.

Мөн судлаач RosellUn (2000) түүхий эдийн эрэлт нэмэгдэхийн хэрээр ГҮД нь улам хатуу (stringent or strict RoO) болж байгааг судалсан бол Ju болон Krishna (2005) нар хатуу хязгаарлалт бүхий ГҮД (restrictive rules of origin) нь дэлхийн бусад улсаас импортлох анхан шатны түүхий эд, материалын импортыг нэмэгдүүлж байна хэмээн дүгнэжээ.

ГҮД-тэй холбоотой бий болох зардал, хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөө, зах зээлд нэвтрэх (market access) байдлын талаарх дийлэнх судалгаанууд нь судлаач Estevadeordal (2000)-ийн ГҮД-ийн хязгаарлалт (Restrictiveness of RoO)-ын талаарх чанарын судалгаанд суурилсан байдаг. Тэрбээр 1–7 гэсэн индексээр ГҮД-ийн хязгаарлалтыг ангилсан бөгөөд ингэхдээ ХАЧХХ (NAFTA)-ийн ГҮД-ийн аргачлалыг ашигласан байна². Ерөнхийдөө гарал үүслийн тухай голлох судалгаануудад “ХАЧХХ-ийн гарал үүсэл” (NAFTA RoO) болон “ПанЕвро систем” (PANEURO)-ийн ГҮД-ийн талаар хийгдсэн судалгаанууд багтаж байна.

Izam (2003), Brenton болон Imagawa (2005), Estevadeoral (2007) нарын эрдэмтэд үйлдвэрлэгч, экспортлогч нарын хувьд гарал үүслийн гэрчилгээ авах процесс нь өөрөө багаггүй зардал, чирэгдлийг бий болгодог хэмээн судалгаандаа дурьджээ. Энэхүү процесс дахь захиргааны зардал, бэрхшээл нь эргээд гэрчилгээ олгоход зүй зохисгүй захиргааны ажиллагаа болон эмх замбараагүй байдал, залилан луйвар үүсэхэд нөлөөлдөг хэмээн тодорхойлсон байна.

² Судлаачын “Хязгаарлалтын индекс” (Restrictiveness Index) нь хоёр үндсэн таамаглалд суурилсан. (1) Бүлгийн түвшний өөрчлөлт нь Зүйлийн түвшний өөрчлөлтийн шалгуураас илүү хатуу буюу хязгаарлалт өндөр, мөн Зүйлийн түвшин өөрчлөгдсөн байх шалгуур нь Мөрийн түвшний өөрчлөлтийн шалгуураас хатуу (БТӨ > ЗТӨ > МТӨ). (2) Өртгийн агууламжийн шалгуур (нэмэгдсэн өртгийн шалгуур) болон үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын тодорхой технологи ашигласан байх шалгуур дээр тарифын ангилал өөрчлөгдөх шалгуурууд нь гарал үүслийн дүрмийг мөрдөхөд улам бэрхшээл бий болгож байгаа гэсэн таамаглал дэвшүүлсэн.

Цаашлаад Manchin болон Pelkmans—Balaoing (2007) нарын судлаачид гарал үүслийн гэрчилгээ олгох хатуу чанд процедураас шалтгаалж экспортлогчдын гарал үүслийн шалгуурын дагуу тухайн бүтээгдэхүүний гарал үүслээ нотлоход зарцуулсан зардал болон хугацаа хоцролт нь ихээхэн нэмэгддэг гэж үзжээ. Тиймээс энэ асуудалтай холбоотой үйлдвэрлэгч, импортлогч нарын эрх, үүргийг тэнцвэржүүлэх нь зүйтэй гэж Harris болон Staples (2009) нар үзсэн.

Үйлдвэрлэгч талаас өөрсдийн бүтээгдэхүүний гарал үүслийн талаар хангалттай мэдлэгтэй байх нь импортлогч тал татвар төлөхөд саад учрахгүй. Харин экспортлогч тал барааныхаа гарал үүслийн талаар хуурамч мэдээлэл өгөх, цалгар хандах нь импортлогч талд татвараа журмын дагуу төлөхөд асуудал дагуулдаг гэж дээрх судалгаануудад дурьджээ.

Эндээс харахад ГҮД-ийн удирдлага (Administration of Rules of Origin) нь байгууллагуудад тодорхойгүй байдлыг авчирч болзошгүй бөгөөд энэ байдал нь гол төлөв гэрчилгээ олгох үйл явц ойлгомжгүй, гаалийн байгууллагын чадамж сул, эсхүл эрх зүйн тогтолцооны дульмаг байдал зэргээс улбаатайг судлаачид нотолдог. Товчоор хэлбэл ГҮД-ийн удирдлагын хүрээнд бий болох хатуу хязгаарлалтууд, нарийн төвөгтэй, тодорхойгүй байдал, үүнээс үүдэлтэй зардал зэрэг нь ЭЗТХ-ийн бүрэн ашиглалт (Full utilization of the ERA)—д сөргөөр нөлөөлөх гол хүчин зүйлс гэдгийг олонх судалгаануудад дэвшүүлжээ.

Сэдвийн судлагдсан байдлаас дүгнэхэд ЭЗТХ-ийг ашиглаж буй байгууллага, ААН-үүдэд ГҮД-ийн хязгаарлалт, өндөр хэмжээний зардал, чирэгдэл нь хэлэлцээрийг анхнаасаа үл ойшоох, цаашид хэлэлцээрийг бүрэн дүүрэн ашиглахгүй байсаар байх эх үндсийг бүрдүүлсээр байна.

Хүснэгт 1. ГҮД-ийн голлох судалгааны ажлуудын нэгтгэл

Зохиогч	Хөнгөлөлтийн схем	ГҮД-ийн нөлөө
Vermulst (1992)	Хөнгөлөлттэй/ хөнгөлөлттэй бус	ГҮД-ийн олон төрлийн аргачлал нь ЧХХ-ийн хүрээнд хөнгөлөлт эдлэх боломжийг хязгаарладаг.
La Nasa III (1993)	НАФТА	ГҮД нь гол төлөв дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах, хэлэлцээрийн бүс нутагт аж үйлдвэрлэлийн процессийг дахин хуваарилахад чиглэсэн байдаг.
Krueger (1993)	Хөнгөлөлттэй	ГҮД нь үйлдвэрлэлийн үр ашигтай орцын эх үүсвэрийг хязгаарладаг. Энэ нь гуравдагч улсын илүү хямд орцыг ашиглах гэсэн үйлдвэрлэгчдийн өрсөлдөөнөөс экспортлогчдыг хамгаалах байдлыг улам нэмэгдүүлдэг

Lloyd (1993)	Хөнгөлөлттэй	ЧХХ-ийн гарал үүсэл нь өргөн хүрээнд даяаршсан үйлдвэрлэлд ямар нэгэн тодорхой хамгаалалтын нөлөө болон худалдааг гажуудуулах хандлага үзүүлээгүй.
Krishna & Krueger (1995)	Хөнгөлөлттэй	Хувь хэмжээгээр тодорхойлогддог (жишээ нь: ӨАШ, хасах арга, нэмэх арга, хуйлах арга г.м) ГҮД-ийн ялгаатай байдал нь тухайн улсын баялаг болон ГШХО-нд багагүй нөлөөг үзүүлдэг.
La Nasa III (1996)	Хөнгөлөлттэй	Гарал үүслийн хэт хатуу дүрэм нь аливаа компанийн худалдан авалт, хөрөнгө оруулалт болон үйлдвэрлэлийн стратегид тодорхойгүй байдлыг бий болгодог.
Falvey & Reed (1998)	Хөнгөлөлттэй	ГҮ-ийн ӨАШ-ийн дүрэм нь үйлдвэрлэлд сөрөг нөлөөлөл үзүүлдэг.
Bhagwati et al. (1998)	Хөнгөлөлттэй	ӨАШ-ын дүрмийг дураараа тодорхойлох, гарал үүслийг тодорхойлох нарийн төвөгтэй дүрмүүд нь үйлдвэрлэлийн даяаршилд олон асуудлыг дагуулж байна.

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

СУДАЛГААНЫ ҮНДСЭН ХЭСЭГ

Судалгааны үндсэн хэсэг нь 4 хэсэгтэй. Үүнд: (1) МУ-ын экспортын тэргүүлэх ач холбогдол бүхий бүтээгдэхүүний ГҮД-ийн судалгаа; (2) Дотоодын эмзэг бүтээгдэхүүний ГҮД-ийн хэлэлцээний хувьд анхаарах асуудал; (3) Салбарын ГҮД-ийн хэлэлцээнд анхаарах асуудлын судалгаа; мөн (4) ГҮД-ийн хэрэглээний олон улсын сайн туршлагад дүн шинжилгээ хийх зэрэг болно.

МУ-ын экспортын давуу талтай бүтээгдэхүүний ГҮД-ийн судалгаа

Гарал үүслийн олон ялгаатай, хатуу чанга дүрмүүд нь бүс нутгийн худалдааны хэлэлцээрүүдэд харилцан адилгүй мөрдөгдөж байгаа бөгөөд ГҮД-ийн зөв ойлголт, тайлбар, гарал үүсэлтэй холбогдох захиргааны процессууд зэрэг нь хэрэгжиж буй нийт ЭЗТХ-үүдийн ашиглалтын түвшин (ЕРА/FTA utilization rate)-д шууд нөлөөлж байгааг олон судалгаа нотолсон байна.

Энэ хэсэгт МУ-ын экспортын тэргүүлэх ач холбогдолтой барааны ГҮД-ийн судалгааг хийсэн. Ингэхдээ Олон улсын худалдааны төв (ИТС)-ийн экспортын потенциалыг тооцох аргачлал (Methodology of export potential index) болон БНСУ-ын зах зээлд МУ-ын экспортын харьцангуй давуу тал (ЭХДТ) бүхий бүтээгдэхүүнийг Барааг тодорхойлох, кодлох, уялдуулсан

систем³ (БТКУС, цаашид уялдуулсан систем-УС гэх)—ийн дагуу ангилан хоёр талын ХДТ—ыг тодорхойлсон индекс туурилан тооцсон.

Эрдэмтэн Бела Баласса (Balassa, 1965) анх харьцангуй давуу талыг тодорхойлох индексийг ашиглах санааг дэвшүүлсэн. Тэрээр тодорхой барааны харьцангуй давуу талын индексийг тухайн барааны тухайн улсын нийт экспортод эзлэх хувийн жинг тухайн барааны дэлхийн нийт экспортод эзлэх хувийн жинд харьцуулах замаар дараах байдлаар томъёолжээ.

$RCA_{ij} = RXA_{ij} = (x_{ij}/X_{it})/(x_{wj}/X_{wt})$ - Revealed comparative advantage or revealed export advantage

x_{ij} — i улсын j барааны экспорт

X_{it} — i улсын t жилийн нийт экспорт

x_{wj} — дэлхийн j барааны экспорт

X_{wt} — дэлхийн t жилийн нийт экспорт

Дээрх ХДТ—тай бараанд БНСУ бусад улстай хийсэн хэлэлцээр (сонгон авсан улсуудаар)—т ямар ГҮД тохирсныг судална. Мөн БНСУ—ын бусад улстай байгуулсан хэлэлцээрийн зарим онцлогийг судлан шигтгээ болгон тайлбарлав. Ингэснээр манай улсын хувьд худалдааны түнш орнуудтай (тухайлбал, БНСУ) хэлэлцээ хийхдээ ГҮД—ээ хэрхэн илүү бодитой, мөн уян хатан байдлаар шийдэж болох талаар харьцуулалт хийх боломжтой болно.

БНСУ—ын зах зээлд МУ—ын ЭХДТ—тай бүтээгдэхүүн дээр БНСУ хэлэлцээр хийсэн улсуудтай гарал үүслийн ямар дүрмийг тохирсон талаар тусгав. Үүнд: БНСУ—АСЕАН, БНСУ—Колумб, БНСУ—БНХАУ, БНСУ—Перу, БНСУ—Австрали, БНСУ—Шинэ Зеландын хэлэлцээрүүдийг багтааж, МУ—ын хувьд ГҮД—ийг Солонгос улстай тохироход харьцуулалт хийв.

БНСУ нь 02 болон 05 дугаар бүлгийн бараа тухайлбал, 020422, 050400, 051000 мөн 150600 гэх мэт бараанд АСЕАН, БНХАУ болон Колумб улстай бүрэн гарал үүсэлтэй бараа байх дүрмээр тохирсон бол сонгож авсан бусад

³ БТКУС.—Улс орнуудын гадаад худалдаанд зохицуулалт хийх, барааны урсгалыг хяналтандаа авах, ялангуяа олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа стратегийн ач холбогдол бүхий барааны хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах шаардлага зэргээс үүдэн Дэлхийн гаалийн байгууллагаас 1983 онд “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем”-ийн тухай Олон Улсын конвенцийг баталсан. БТКУС-ийн Конвенцийн 161 хэлэлцэн тохирогч тал, 200 гаруй улс орон, мөн эдийн засгийн болон гаалийн холбоод гаалийн тарифын болон тарифын бус арга хэмжээг тогтоох, олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээр хийх, зарим нэр төрлийн барааг гаалийн татвараас чөлөөлөх, гаалийн хөнгөлөлт үзүүлэхэд ашиглаж байна. ДГБ-аас эмхтгэн боловсруулсан уг конвенци нь Удиртгал, 20 зүйл, Уялдуулсан систем /УС/-ийн Жагсаалт, УС-ийн Ерөнхий тайлбар дүрэм, хэсэг, бүлэг мөрийн тайлбар бүхий хавсралтаас бүрддэг. Одоогийн байдлаар дэлхийн худалдааны эргэлт дэх барааны 98%-ийг энэ системийн дагуу ангилж байгаа нь олон улсын худалдааны хууль ёсны суурь ангилал болоод байна”.

Эх сурвалж: <https://customs.gov.mn/>

хэлэлцээрт үүнээс гадна бүлгийн түвшин өөрчлөгдсөн байх (БТӨ) дүрмийн шалгуурыг ашиглажээ.

Харин 25, 26, 27 дугаар бүлгийн бараанууд болох 252921, 260300, 260111, 260800, зэрэг манай улсын экспортын гол нэрийн олборлох салбарын бараанд АСЕАН-аас бусад сонгосон улс зүйлийн түвшин өөрчлөгдөх (ЗТӨ) шалгуурыг мөрдөж байна. Перу улсын хувьд 270111 болон 270112 кодтой чулуун нүүрс, нунтагласан ба бөөмнөрүүлсэн, мөн чулуун нүүрс; чулуун нүүрснээс гаргаж авсан брикет, шахмал нүүрс болон эдгээртэй төстэй хатуу түлшинд мөрийн түвшин өөрчлөгдөх (МТӨ) шалгуур, өртгийн агууламжийн шалгуур (ӨАШ— тухайн барааны ФОБ үнийн 40%-иас багагүй байх шалгуур)—ийн аль нэгийг “сонгох” байдлаар хэрэглэж байна.

МУ-ын экспортын ХДТ-тай 51 дүгээр бүлгийн барааны хувьд (510510, 510529, 510531, 510810 г.м) Колумб, БНХАУ, Перу Австрали гэсэн улсуудтай хэлэлцээр хийхдээ БТӨ-ийн шалгуурыг мөрдөж байгаа бол АСЕАН болон Шинэ Зеландтай ЗТӨ-ийн шалгуурыг хэрэглэж байна. АСЕАН-ы хувьд УС-ийн 510539 сэмлэсэн эсвэл самнасан, хонины ноос буюу мал, амьтны нарийн эсвэл бүдүүн үс, ноос, хялгас гэсэн бараанд бүлгээс зүйлийн түвшин өөрчлөгдөх шалгуур эсвэл ӨАШ-ийн аль нэгийг мөрдөхөөр заажээ.

Харин 510810 кодтой барааны хувьд (жижиглэн худалдаалах зориулалтаар савлаагүй, мал, амьтны нарийн үс, ноосон сэмлэсэн эсвэл самнасан ээрмэл) зүйлээс ЗТӨ шалгуур эсвэл ӨАШ (>40%)—ийг мөрдөж байна. Энэ барааны хувьд бусад улсууд нилээд нарийн шалгуурыг тавьж өгсөн байна. Жишээ нь: Колумб улстай ЗТӨ-ийн шалгуурыг тохирсон ч зүйлийн 5106—5110-аас бусад бараанд гэсэн бол Перу улсын хувьд зүйл 5106—5110, 5205—5207, мөрийн 5402.11—5402.45, 5404.12—5404.90, зүйлийн 5406—5511-ээс бусад бараанд хамаарна гэсэн байна.

УС-ийн 511111 кодтой барааны хувьд БТӨ, ӨАШ (>40%) шалгуураас гадна будах, хээлэх процесс нь багадаа хоёр бэлтгэх, боловсруулах үйл ажиллагааны хамт хийгдсэн байх, Австралитай хийсэн хэлэлцээрийн хүрээнд даавуу үйлдвэрлэлээс эхлэх боловч аль нэг талын нутаг дэвсгэр дээр будах, хээлэх процесс нь бэлтгэх, боловруулах үйл ажиллагааны хамт хийгдэх шаардлаггүй гэж заажээ. Ерөнхийдөө хэлэлцээрүүдэд УС-ийн 50—63 дугаар бүлэг нь оёмол сүлжмэл, нэхмэл эдлэлийн бүтээгдэхүүний “тусгай дүрэм”—д хамаардаг байна.

61 дүгээр бүлгийн 611012, 611019, 610210, 610441, 610451 кодтой бараанууд дээр БНСУ сонгосон 6 улстай хэлэлцээр хийхдээ гол төлөв БТӨ шалгуурыг мөрдөж байна. Өмнө дурдсанчлан шалгуурын хязгаарлалтын хувьд БТӨ шалгуур нь ЗТӨ, МТӨ шалгуураас хүнд, хатуу шалгуурт тооцогддог. Манай орны хувьд цөөн биш бараа уг ангилалд экспортын давуу талтай байгаа

боловч Солонгос улс хатуу шалгуур тавьж байгаа нь дотоодын экспортлогчдод багаггүй хүндрэл үүсгэж болзошгүйг харуулж байна⁴. Тиймээс хэлэлцээ хийхдээ аль болон уян хатан шалгуурын хамт эсвэл сонгож хэрэглэхээр зааж өгөх талыг баримтлах нь зүйтэй гэж үзэж байна.

Энэ бүлгийн ЭХДТ бүхий бараанд БТӨ гадна аль нэг талын нутаг дэвсгэрт эсгэх (хэлбэр оруулан сүлжих—*knit to share*), оёх процессийн хамт мөрдөхөөр АСЕАН—тай болон Перу улстай байгуулсан хэлэлцээрт тус тус заасан байна. Колумб болон Перу улстай ГҮД—ээ эдгээр бараанд БТӨ шалгуурыг тавихын зэрэгцээ зүйлийн Колумбтай 5106—5113, 5204 — 5212, 5401—5402, 5404, 5407—5408, 5508—5516, мөн 6001—6006 кодтой бараануудыг хамруулахгүй, Перу улстай 5106—5113, 5205—5212, 5306—5311, мөрийн түвшний 5402.11—5402.39, 5402.45—5402.69, 5404.12—5404.90, зүйлийн 5406—5408, 5509—5516 6001—6006 кодтой бараануудыг хамруулахгүй байхаар заасан. Харин Хятад, АСЕАН—тай БТӨ болон ӨАШ (>40%)—ийг тохирсон байна.

62 дугаар бүлгийн 621420, 620111, 620211 кодтой барааны хувьд Номхон далайн орнуудтай зөвхөн БТӨ шалгуур тохирсон бол АСЕАН, Хятадтай БТӨ нь аль нэг талд эсгэх, оёх процесс хийгдсэн байхаар эсвэл ӨАШ (>40%) мөрдөгдөж байна. Хамгийн сүүлд давуу тал бага 780199 кодтой боловсруулаагүй хар тугалга (цэвэршүүлсэн хар тугалга ба жинд антигоми агуулсан хар тугалга хамаарахгүй) нь сонгож авсан 6 хэлэлцээр дээр бүгд ЗТӨ шалгуураар тохирчээ. БНСУ—АСЕАН—ы хэлэлцээрт 150600, 252921, 260300, 260111, 260800, 260700, 261390, 261100, 270900, 270111, 270112 кодтой бараанд гарал үүслийн дүрэм тохироогүй.

Манай орны хувьд ЭЗТХ байгуулах гэж буй орны онцлог байдал, зах зээл, барааны бүтэц, салбарын бодлогыг өргөн хүрээний судалгаагаар нухацтай авч үзэсний үндсэн дээр гарал үүслийн дүрмийг нарийн тохиролцох шаардлагатай байгаа нь харагдаж байна. Ингэхдээ МУ—ын экспортлогчдод аль болох саад бага учруулахаар, хэт өндөр хязгаарлалт тавихгүй гарал үүслийн дүрэм тохирох хэрэгцээ үүсэж байна.

Экспортын давуу тал өндөртэй манай 50—63 дугаар бүлгийн бараанд БНСУ—ын Колумб, Перу, Австрали, Шинэ Зеланд улсуудтай хийсэн хэлэлцээр нь БТӨ, ЗТӨ—ийг өөр дүрэмтэй сонголттой байдлаар хэрэглэх байдлыг тусгаагүй харин АСЕАН болон БНХАУ—тай хийсэн хэлэлцээрүүдэд БТӨ, ЗТӨ шалгуураас гадна ӨАШ—ийн 40%—ийн дүрмийн аль нэгийг сонгох байдлаар зааж өгсөн.

⁴ Сүүлийн жилүүдэд МУ—аас экспортын боломжтой бараа 081090.10 буюу чацаргана дээр бүрэн гарал үүсэлтэй байх шалгуурыг мөрдөж байна. Гэхдээ Японтой байгуулсан хэлэлцээрт гарч буй асуудал нь чацарганы тос болон шүүний БТКУС код байхгүйгээс бизнес эрхлэгчдэд хүндрэл үүсгэж байгааг Шар Доктор ХХК онцолжээ.

Тиймээс Монгол улсын хувьд зөвхөн нэг дүрмээр хатуу тохирохгүй сонголтот байдлаар ГҮД-ийг экспортын давуу талтай бараанд тохирох нь илүү ашигтай гэж үзэж байна.

Шигтгээ 1. БНСУ -ын бусад улстай хийсэ ГҮД-ийн тохиролцоо

МУ-ын экспортын давуу талтайд тооцогддог 570241 хонины ноосон нэхмэл хивс нь Япон улсын талд тарифын хөнгөлөлт эдлэж чадахгүй байгаа бөгөөд ЭЗТХ-ийн 3 дугаар бүлгийн 2 дугаар хавсралтад “Бүтээгдэхүүний тусгам дүрэмд заасан шаардлагыг хангахгүй байна. Учир нь энэхүү заалтын (i) уялдуулсан системийн 1-ээс 49 дүгээр бүлэг, 64-өөс 97 дугаар бүлэгт заасан барааны хувьд, тухайн барааны өртгийн 10 хувь, (ii) уялдуулсан системийн 50-иас 63 дугаар бүлэгт заасан барааны хувьд тухайн барааны жингийн 10 хувь хэмээн тохирчээ.

Харин ASEAN-БНСУ-ийн хэлэлцээрт ЗТӨ эсхүл ӨАШ (>40%), БНСУ-Перугийн хэлэлцээрт БТӨ (5106-5113, 5205-5212, 5307-5308, 5310-5311, 5402, 5404, 5406-5408, эсхүл 5509-5516-аас бусад), БНХАУ-БНСУ-ын хэлэлцээрт БТӨ (52.05 - 52.07, 54.01-54.02, 54.04, 54.07-54.08, эсхүл 55.08 - 55.168) эсхүл ӨАШ (>40%) гэж тус тус заасан. Энэхүү жишээнээс бид бүхэн дараа дараагийн хэлэлцээрүүдэд хонины ноосон хивсний гарал үүслийн дүрмийг уян хатан, сонголтот байдлаар тохирох нь эцэстэй юм. БНСУ-Турк улсын хэлэлцээрт процессийн шалгуур (working or processing) бол БНСУ-Энэтхэг хоорондын хэлэлцээрт 50.01-60.06 кодтой бараанд ЗТӨ+ӨАШ (>40%) хамт мөрдөхөөр тус тус заажээ.

Эх сурвалж: БНСУ-ын байгуулсан хэлэлцээрүүдийн баримт бичгээс нэгтгэв.

Дотоодын эмзэг бүтээгдэхүүнүүдийн ГҮД-ийн судалгаа

Өмнөх хэсэгт БНСУ-ын ХДТ-тай бараа болон МУ-ын ХДТ бүхий барааны гарал үүслийг бусад улстай Солонгосын тал хэрхэн тохирсон талаар судалсан. ХДТ-тай экспортын барааны бүтцээс үзэхэд БНСУ-аас манай улсын хувьд импортлох бүрэн боломжтой барааны жагсаалтад МУ өөрөө дотооддоо үйлдвэрлэдэг эмзэг болон хэт эмзэг салбарын барааны нэр төрөл бараг байхгүй байна. Харин УС-ийн 190230-гоймон, 330499-гоо сайхны бэлдмэл эсвэл нүүр будалт хийх бэлдмэл, биеийн арьс арчилж, хамгаалах бэлдмэл гэсэн бараа нь манай улсын хувьд цаашид үйлдвэрлэл хөгжих боломжтой бараа гэж үзэж болно.

Эдгээр барааны тухайд экспортын потенциал болон бодит экспортын нөхцөл байдлыг судалсан бөгөөд дараах байдалтай байна.

**Хүснэгт 2. БНСУ–аас МУ–д экспортлох гоо сайхны барааны
худалдаа**

Код	Экспортын потенциал	Бодит экспорт	Зөрүү
330499	9.7 сая ам.долл	6 сая ам.долл	3.7 сая ам.долл
330510	794 мян ам. долл	1.4 сая ам долл	—
330590	476 мян ам. долл	457 мян ам. долл	20 мян ам. долл
340130	388 мян ам. долл	331 мян ам. долл	57 мян ам. долл
330610	261 мян ам. долл	382 мян ам. долл	—
340111	81 мян ам. долл	62 мян ам. долл	20 мян ам. долл
340119	99 мян ам. долл	88 мян ам. долл	11 мян ам. долл
330300	17 мян ам. долл	14 мян ам. долл	3 мян ам. долл
330491	132 мян ам. долл	522 мян ам. долл	—

Эх сурвалж: ITC Export Potential Map, <https://exportpotential.intracen.org>

Эндээс зарим гоо сайхны бараа, тухайлбал гоо сайхны бэлдмэл эсвэл нүүр будалт хийх бэлдмэл, биеийн арьс арчилж, хамгаалах бэлдмэл, шүд цэвэрлэгээний бэлдмэл, нягтруулсан эсвэл нягтруулаагүй энгэсэг гэсэн бараануудын бодит экспорт потенциалаасаа давсан үзүүлэлттэй харагдаж байна. МУ-ын хувьд сүүлийн жилүүдэд гоо сайхны барааг дотооддоо үйлдвэрлэж, өөрийн гэсэн хэрэглэгчидтэй болоод байгаа ч эдгээрийг бусад улсаас ялангуяа Солонгосоос түлхүү импортлодог. БНХАУ– БНСУ–ын хэлэлцээрт 33 болон 34 дүгээр бүлгийн бараанд ЗТӨ шалгуур, ASEAN–тай байгуулсан хэлэлцээрт ЗТӨ эсхүл ӨАШ (>40%), Колумб улстай ЗТӨ эсхүл ӨАШ хасах аргаар (>40%), Перу улстай ЗТӨ эсхүл ӨАШ (50%) гэх мэт ялгаатай тохирсон байна.

Харин МУ, Японы ЭЗТХ–т 33 дугаар бүлгийн бараанд ЗТӨ эсхүл (>40%), 34 дүгээр бүлгийн бараанд МТӨ эсхүл (>40%), зарим бараанд ЗТӨ эсхүл (>40%) гэж тохирсон нь харьцангуй зөөлөн хэлбэртэй тохиролцоо гэж үзэж байна. МУ–аас байгалийн гаралтай, органик гоо сайхны бараа Солонгосын зах зээлд экспортлох боломж их байгаа учраас энэ тал дээр харьцангуй зөөлөн дүрэм мөрдөх нь зөв хэдий ч эргээд айлын талаас гоо сайхны бараануудын импорт одоо байгаа дээр өсөх магадлалтай юм.

Гэвч зарим улсын хэлэлцээр байгуулсан практикаас харахад эмзэг болон хэт эмзэг салбарын барааг хэлэлцээрийн хүрээнд Х буюу тухайн гаалийн тарифыг бууруулахгүй мөн хэлэлцэхгүй гэсэн ангилалд хамруулдаг. Гэсэн ч эмзэг, мэдрэмтгий салбарын худалдаа чөлөөт худалдааны хэлэлцээрийн хүрээнд тодорхой түвшинд хийгдэх нь үнэн тул энэ талаар улс орнууд ямар дүрэм баримталдгийг судлаж үзэв.

Ингэхдээ ГҮД-ийн аль нь хатуу, хязгаарлалт өндөртэй шалгуур вэ гэдгийг мөн л зайлшгүй ойлгох шаардлагатай. Үүний тулд бид зарим эрдэмтдийн судалгааг харьцуулсан ба Estevadeoral (2000)-ийн *Гарал үүслийн дүрмийн хязгаарлалт (Restrictiveness of RoO)*-ын талаарх чанарын судалгаанд суурилсан байдаг. Уг судалгаа нь дүрэмтэй холбоотой гарах зардал, хөрөнгө оруулалтад үзүүлэх нөлөө, зах зээлд нэвтрэх байдлын талаарх дийлэнх судалгаануудад өргөнөөр ашиглагдаж байдаг.

ГҮД-ийн хязгаарлалт (Restrictiveness of RoO)-ын индекс буюу хэлэлцээрүүдэд мөрдөгдөж буй гарал үүслийн дүрмүүд нь хэр зэрэг хатуу байгаа үнэлгээг 1–7 гэсэн индексийн түвшинд ангилсан бөгөөд ингэхдээ ХАЧХХ (НАФТА)-ийн дүрмийн аргачлалыг ашигласан байна. 1 гэсэн индекс нь тухайн ГҮД нь харьцангуй хөнгөн, харин 7 гэсэн индекс нь хамгийн хатуу хэлбэрийн дүрэм гэдгээр тайлбарласан (Хүснэгт 3).

Гэхдээ ГҮД нь хэт хатуу (Restricted/ Stringent RoO) байвал тарифын хөнгөлөлт эдлэх боломж багасна, бас хэт зөөлөн (Liberal RoO) байвал эдийн засгийн сөрөг үр дагаварууд гарах эрсдэлтэй байдгийг санах нь зүйтэй. Хөгжиж байгаа орны хувьд мэдээж экспортоо дэмжих, нэмэгдүүлэх, хэлэлцээрийн түнш орны зах зээлд саадгүй нэвтрэх болон бусад зорилгын үүднээс аль болох хатуу гарал үүслийн дүрмээс татгалзсан тохироо хийх нь зүйтэй ч хэт зөөлөн дүрмийг баримтлах нь учир дутагдалтайг анхаарах нь зөв.

Хүснэгт 3. Estevadeoral-ийн тодорхойлсон ГҮД-ийн хязгаарлалтын индекс

Индекс	Тайлбар
1	УС-ийн 8–10 орны түвшний өөрчлөлт
2	Индекс 1–ээс илүү хатуу. УС-ийн 6 орны түвшинд (МТӨ) өөрчлөгдөх
3	Индекс 2–ээс илүү хатуу. УС-ийн 6 орны түвшинд өөрчлөгдөх (МТӨ) & ӨАШ
4	Индекс 3–аас илүү хатуу. УС-ийн 4 орны түвшинд өөрчлөгдөх (ЗТӨ)
5	Индекс 4–өөс илүү хатуу. УС-ийн 4 орны түвшинд өөрчлөгдөх (ЗТӨ) & ӨАШ
6	Индекс 5–аас илүү хатуу. УС-ийн 2 орны түвшинд өөрчлөгдөх (БТӨ) & ӨАШ
7	Индекс 6–аас илүү хатуу. УС-ийн 2 орны түвшинд өөрчлөгдөх (БТӨ) & үйлдвэрлэлийн/боловсруулалтын тодорхой технологи ашигласан байх

Эх сурвалж: Estevadeoral (2003)-ийн бүтээлээс нэгтгэв.

Тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм нь аливаа бараа бүтээгдэхүүн (чөлөөт худалдааны хэлэлцээрийн гишүүн бус улс эсхүл хөнгөлөлтийн системийн ашиг үл хүртэгч улсаас импортлосон) нь гишүүн улс руу экспортлогдохдоо УС-ийн дагуу тарифын ангилал өөрчлөгдсөн барааг хамааруулна. Энэхүү ангиллын өөрчлөлт нь УС-ийн 2, 4, 6 орны түвшинд болон үндэсний кодын түвшинд өөрчлөгддөг. Зарим тохиолдолд тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм нь зохих гарал үүсэлгүй (импортын) барааны хэрэглээг Уялдуулах системийн бүлэг, зүйл, мөрийн түвшнөөс хасдаг.

Тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм нь олон улсын худалдааны ангиллын системд ашиглагдаггаараа олон давуу талтай боловч УС-ийн дагуу тарифын ангилал нь шинжлэх ухаан гэхээс илүү чөлөөт шинжтэй (олон барааг яг ижил ангилалд багтаах боломжгүй гэдэг талаасаа) бөгөөд маш өргөн хүрээний экспертиз хийх шаардлагыг үүсгэдэг⁵.

Цаашилбал УС нь ГҮД-д зориулагдаагүй бөгөөд 4 жил тутамд шинэчлэгддэг байдал нь тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм өөрөө УС-ээ дагаад шинэчлэгдэх болдог нь мөн л өндөр түвшний экспертизийг шаардана. Гэсэн хэдий ч тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм нь бодит байдал дээр хэрэглэхэд хамгийн дөхөм дүрэм гэдгээрээ илүү үр дүнтэй байдаг. Аль нэг тал нь материалын өртгийг тодорхойлж, импортын материал нь тарифын ангилал өөрчлөгдөх шалгуурыг хангаж буй эсэхийг тогтооход хялбар.

Тарифын ангилал өөрчлөгдөх дүрэм нь УС-ийн 4–5 жилд шинэчлэгдэх шинэчлэлийг дагаад зарим тохиолдолд хэрэглэхэд хүндрэлтэй болно. Энэхүү шинэчлэх үйл явцад бараа бүтээгдэхүүнүүдэд шинэ бүлэг үүсгэх болон зүйлийн түвшинд ангилагдах шаардлага үүсдэг. Энэ тохиолдолд гарал үүслийн дүрэмд зайлшгүй техникийн засварууд хийх хэрэгцээтэй болох бөгөөд энэ нь эргээд зарим үйлдвэрлэгчдийн хувьд дахин шинэ дүрэм суралцах шаардлагыг бий болгох ч үйлдвэрлэлийн процессийн хувьд зохих гарал үүсэлтэй барааг үйлдвэрлэх явц үргэлжилсээр байна⁶.

⁵ UNCTAD (2011). Rules of Origin Procedures Applicable to Exports from LDCs (*Tariff classification under the Harmonized System is often more of an art than a science (i.e. many products do not fit neatly into one classification) and requires a considerable amount of expertise*).

⁶ UNCTAD (2011). Rules of Origin Procedures Applicable to Exports from LDCs.

Шигтгээ 2. БНСУ – Чили ГҮД

БНСУ–Чили улсын 2 талт хэлэлцээр нь нэг төрлийн НАФТА–гийн гарал цүслийн дүрмийн хэлбэр буюу хатуу гарал цүслийн дүрэмтэйд тооцогддог. Ялангуяа мэдрэмжтэй барааны хувьд маш нарийн төвөгтэй гарал цүслийн дүрэмд тооцогддог. Тухайлбал, хөдөө аж ахуй, загас агнуурын эмзэг, мэдрэмжтэй бараатай холбоотой УС–ийн 01–10 дугаар бүлэгт ЗТӨ–ийн шалгуур мөрддөг. Үл тооцох хувь нь 8 хувь байдаг.

Мөн ЗТӨ болон ӨАШ хэд хэдэн бүлэгт цуг хэрэглэгддэг. Үүнд: УС–ийн 19, 29, 30, 31, 38 дугаар бүлгийн бараанууд хамаарна. Ерөнхийдөө хасах аргын ӨАШ нь багадаа 45 хувь, нэмэх аргын хувьд 35 хувь байна. УС–ийн 84 дүгээр бүлгийн зарим барааны хувьд нэмэх аргын ӨАШ нь 30 хувьтай.

Гэхдээ УС–ийн 2008.92–2008.99 (бусад аргаар бэлтгэсэн хүнсний ногоо, жимс, самар болон ургамлын хүнсэнд хэрэглэх бусад эд хэсэг) гэсэн бараанд ӨАШ маш өндөр бөгөөд энэ нь Чили улсын бус жцүс болон ижил төрлийн барааг хязгаарлах зорилготой. Жишээ нь савтай жцүсний гарал цүслийн ӨАШ–ийг 80%–иар тохирсон.

Эх сурвалж: Cheong & Cho (2006).*

* Cheong and Cho (2006). Market Access in FTAs: Assessment based on Rules of Origin and Agricultural Trade Liberalization

Шигтгээ 3. БНСУ – БНАСАУ, Сингапурын ГҮД

БНСУ–Сингапур хоорондын хэлэлцээр нь 2004 оны эхээр хэлэлцээ хийгдэж, харьцангуй хурдан хугацаанд буюу 2006 оны 3 дугаар сард хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн хэлэлцээр юм. Хоёр улсын хэлэлцээрийг далимдуулан Сингапур улсаар дамжих хууль бус тээвэрлэлтэд БНСУ–ын тал санаа зовниж, нилээд хатуу гарал үүслийн дүрмийг тогтоохыг санал болгосон (эндээс гарал үүслийн хатуу дүрэм нь гагцхүү эмзэг бараанд мөрдөгдөггүй болох нь харагдаж байна).

Харин Сингапурын хувьд гуравдагч оронд үйлдвэрлэх (outward processing⁷) саналыг оруулахыг зорьж байсан. Учир нь БНСУ нь БНАСАУ–д байрлах Гесонг (Gaesung Industrial Region/Complex⁸) аж үйлдвэрийн бүсэд Солонгосын захиалгаар үйлдвэрлэсэн барааны гарал үүслийг хэрхэн тохирох талаар санаа зовж байсан.

Энэхүү аж үйлдвэрийн бүс нь Хойд Солонгосын нутаг дэвсгэрт байрладаг гэдэг утгаараа Өмнөд Солонгосын хувьд энд үйлдвэрлэсэн барааг Өмнөд Солонгосын бараа хэмээн хүлээн зөвшөөрүүлэх асуудалд ач холбогдол өгч байсан. Уг үйлдвэрлэлийн бүс нь хоёр Солонгосын эдийн засгийн үр өгөөж талаасаа болон 2 талын найрамдалт харилцааны бэлгэдлийн агуулга талаасаа ач холбогдолтой бүсэд тооцогддог, онцлог район байна. Солонгос улс нь Сингапурын оруулсан гуравдагч оронд үйлдвэрлэхийг хүлээн зөвшөөрөх тохиолдолд дээрх асуудалд Сингапурыг хүлээн зөвшөөрүүлэх гэж хичээсэн байна. 2 тал аль аль нь үл тооцох хувийг 10 хувь байхаар тохирсон. Харин оёмол сүлжмэлийн барааг хамруулахгүй байхаар тохиролцсон.

Чили улстай хийсэн хэлэлцээрийн хувьд нэмэх аргын ӨАШ нь 45, 50, 55 хувиар тохирсон байна.

Эх сурвалж: Cheong & Cho (2006).

Салбарын ГҮД–ийн хэлэлцээний судалгаа

БНСУ–ын байгуулсан нийт хэлэлцээрүүдээс 2010 онд Энэтхэг улстай байгуулсан хэлэлцээр зарим салбараар гарал үүслийн дүрмээ тохирсон байна⁹. Тухайлбал, 60–60 дугаар бүлгийн бараа ЗТӨ+ӨАШ (>40%), 61–63 дугаар бүлгийн бараа процессийн шалгуур буюу зохих гарал үүсэлгүй утаснаас эхлэн үйлдвэрлэх (manufacture from non-originating yarn), 41, 42

⁷ Гуравдагч улсад үйлдвэрлэх процесс буюу “outward processing” гэдэг нь аливаа үйлдвэрлэлийн процессийн нэг хэсэг (хөдөлмөр буюу ажиллах хүч их шаардсан–labor intensive works) нь хөгжил буурай оронд явагдахыг ойлгоно. Тухайлбал, үйлдвэрлэлийн 2 дугаар үе шатанд хөдөлмөрийн хүч илүү шаардлагатай тохиолдолд үүнийг гуравдагч хөгжил буурай орноос аутсорс хийх замаар шийднэ. Энэ нөхцөлд үйлдвэрлэлийн 1 болон 3 дахь шатанд өртгийн агууламж (local content) бий болохоор байна

⁸ Дэлгэрэнгүй мэдээллийг дараах хуудаснаас үзнэ үү.
<https://www.bbc.com/news/business-22011178>
https://www.unikorea.go.kr/eng_unikorea/relations/statistics/gic/

⁹ <https://english.motie.go.kr/en/if/ftanetwork/ftanetwork.jsp>

дугаар бүлэг ЗТӨ гэх мэт тохирсон байна. БНСУ–ын байгуулсан дараах 4 хэлэлцээрийн тухайд салбарын гарал үүслийн хязгаарлалтын судлаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд: Анхан шатны бүтээгдэхүүн, боловсруулсан анхан шатны бүтээгдэхүүн болон оёмол, сүлжмэлийн салбарын дүрэм нь илүү хатуу, чанга байгааг Чили, Сингапур, ЕФТА болон ASEAN–тай байгуулсан хэлэлцээрүүдээс харж болно.

Хүснэгт 4. БНСУ–ын байгуулсан ЧХХ–ийн гарал үүслийн дүрмийн хязгаарлалт

	БНСУ – Чили	БНСУ – Сингапур	БНСУ – ЕФТА	БНСУ– АСЕАН
Салбар	6.00	5.99	6.98	6.89
Primary products	5.77	5.74	5.86	5.19
Processed primary products	4.66	4.00	3.99	4.00
Processed mineral products	3.98	4.13	4.02	3.99
Chemical & rubber products	4.86	4.27	4.00	4.03
Leather products	4.21	4.00	4.00	4.00
Textiles & clothes	5.83	5.25	5.16	5.44
Nonmetallic mineral products	5.20	4.69	3.72	3.85
Metal products	5.51	4.25	4.07	3.99
General machinery	4.22	4.07	4.17	3.99
Electrical machinery	4.05	4	4.08	3.85
Transport equipment	4.39	4.68	4.03	4.33
Other transport equipment	4.59	4.26	4.02	4.00
Precision machinery	4.14	4.07	4.45	3.96
Other manufacturing	4.90	4.33	4.28	4.02
Total	4.82	4.59	4.59	4.53

Эх сурвалж: Kim & Cho. (2010).

Дээрх хүснэгтээс харахад Солонгос, ЕФТА–гийн хооронд байгуулсан хэлэлцээр нь байгуулсан бусад хэлэлцээртэй харьцуулахад гарал үүслийн илүү хатуу дүрмийг боловсруулсан анхан шатны бүтээгдэхүүн (6.98) дээр баримталдаг болох нь харагдаж байна. Харин Чилитэй байгуулсан хэлэлцээрийн хувьд оёмол, сүлжмэл салбарт гарал үүслийн дүрэм нь хатуу (5.83) тогтоосныг харуулж байна. Ерөнхийдөө Солонгосын худалдааны түнштэйгээ байгуулсан хэлэлцээрийн ГҮД–ийн хязгаарлалтын индекс 4–5 гэсэн индексийн хооронд хэлбэлзэж байна. Гэтэл НАФТА болон ПанЕвро системийн гарал үүслийн дүрмийн индекс нь 5.1, 4.5 гэсэн түвшинд тус тус хүрдэг. Үүнээс дүгнэхэд БНСУ–ын хувьд сонгож авсан дээрх 4 хэлэлцээрт мөрдөж буй салбарын гарал үүслийн дүрэм нь НАФТА–гийн гарал үүслийн дүрмээс хатуу байдал

нь илүү бага ч ПанЕвро дүрмээс илүү чанга хэмээн дүгнэгдэж байна.

Дөрвөн улс болон бүс нутагтай байгуулсан хэлэлцээрийн хувьд ГҮД-ийн шалгуур хэт чанга бус байгааг энд онцлоод үүний гол шалтгаан нь эдгээр хэлэлцээрүүдэд мөрийн түвшний өөрчлөгдөх шалгуур нэмэгдсэнтэй холбож үзэж болох юм.

Хүснэгт 5. БНСУ-ын 4 хэлэлцээрт мөрдөж буй салбарын гарал үүслийн дүрэм

	БНСУ – Чили	БНСУ – Сингапур	БНСУ – ЕФТА	БНСУ – ASEAN
БТӨ+	1,867	1,257	482	552
ЗТӨ+	3,102	3,799	3,990	4,087
МТӨ+	202	137	34	61
Бусад шалгуур	53	31	718	524
Нийт	5,224	5,224	5,224	5,224

Эх сурвалж: Kim & Cho. (2010).

Хэлэлцээрүүдээс хамгийн чанга дүрэмтэй салбарын хувьд анхан шатны бүтээгдэхүүн орж байгаа бөгөөд 7 буюу гарал үүслийн дүрмийн хамгийн хатуу индексстэй зэрэгцэж очсон байна. Ялангуяа ASEAN болон ЕФТА-гийн бүс нутагтай хийсэн хэлэлцээр анхан шатны бүтээгдэхүүний индекс 6.98/7.00, 6.89/7.00 гэсэн байдалтай байна. Үүний дараа сонгож авсан хэлэлцээрүүдэд боловсруулсан анхан шатны бүтээгдэхүүн болон оёмол, сүлжмэлийн салбарын индекс 5–6-ийн хооронд байгаа бөгөөд энэ салбарт манай улсын хувьд Солонгосын зах зээлд харьцангуй давуу тал өндөртөйд тооцогддог бүтээгдэхүүн багтдаг.

ГҮД-ийн хэрэглээний олон улсын сайн туршлага

Энэ хэсэгт дэлхийн бусад улсууд гарал үүслийн дүрмээ хэрхэн тохирч байгаа болон БНСУ-ын хэлэлцээрүүдэд мөрдөж буй гарал үүслийн дүрэмтэй харьцуулан судлав.

Дараах хүснэгтээс харахад жишээ авсан бүс нутгийн хэлэлцээрүүдэд бүрэн гарал үүсэлтэй бараа байх шалгуур, тарифын ангилал өөрчлөгдөх шалгуур, өртгийн агууламжийн шаардлага, үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын технологи ашигласан байх шалгууруудыг мөрдөж байна.

Хүснэгт 6. ГҮД-ийн хэрэглээ (сонгосон хэлэлцээрийн жишээн дээр)

	Бүрэн гарал үүсэлтэй бараа байх	Үлэмж хэмжээний боловсруулалтын шалгуур		
		Тарифын ангилал өөрчлөгдсөн байх	Өртгийн агууламжийн шаардлага	Үйлдвэрлэлийн/ боловсруулалтын технологи ашигласан байх
НАФТА			➤ a	
ЕЭЗБ				
ЕЧХХ				
ЕХ–Мексик				
ЕЧХХ–Сингапур				
АНУ–Сингапур			➤ b	
АСЕАН ЧХХ		–		
АСЕАН–БНХАУ			➤ c	
Япон–Сингапур				
Япон–Мексик				
<i>БНСУ–Чили</i>			➤ d	
<i>БНСУ–Сингапур</i>				

Тэмдэглэгээ: • – дийлэнх бараанд хэрэглэгдэж буй, o – цөөн нэр төрлийн бараанд хэрэглэгдэж буй

- a – ӨАШ нь 60 хувиас багагүй байх (хэлцлийн үнийн арга бол) эсхүл 50 хувь (нийт өртөг тооцох арга бол) 62.5 хувь – автомашины хувьд нийт өртөг тооцох аргад суурилсан (УС-ийн 8702.хх, 8703.21–90, 8704.21, 8704.31 бараанд)
- b – ӨАШ нь нэмэх аргаар 35 хувь, хасах аргаар 45 хувь байх
- c – АСЕАН–Хятадын ЧХХ-ийн гишүүн бус улсаас гаралтай материал (СИФ) 60 хувиас багагүй (эцсийн бүтээгдэхүүний ФОБ үнэ) байх
- d – ӨАШ нь нэмэх аргаар 30 хувь, хасах аргаар 45 хувь байх (Лаазтай шүүсний хольц 80 хувь гэж онцгойлон заасан).

БНСУ-ын анхны 2 талт хэлэлцээр болох Чили, Сингапур улстай байгуулсан хэлэлцээрүүдийн хувьд шалгуурууд ерөнхийдөө ижил төсөөтэй ангилалтай. Гэхдээ Сингапуртай хийсэн ЧХХ-ийн хувьд зарим шалгууруудыг бууруулсан байна. Мөн 2 талын хэлэлцээрт *хамгийн их давтагдаж* буй дүрэм нь зүйлийн түвшний өөрчлөлт (ЗТӨ)-ийн шалгуур байна. Мөрийн түвшний өөрчлөлтийн шалгуур мөн 2 талт хэлэлцээрт мөрдөгдөж байна.

Дараах хүснэгтээс харахад БНСУ–ын хувьд Сингапур улстай байгуулсан хэлэлцээр нь Чили улстай байгуулсан хэлэлцээртэй харьцуулахад илүү зөөлөн гарал үүслийн дүрэм мөрдөж байгаа буюу 6 болон 7 ангилалд хамаарах шалгуурууд харьцангуй цөөн байна. Тиймээс эхэлж байгуулсан хэлэлцээрээс илүү дараагийн хэлэлцээрүүдийн ГҮД-ийн шаардлагуудын хязгаарлалтууд илүү багасаж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 7. БНСУ–Чили ЧХХ, БНСУ–Сингапур ЧХХ–ийн ГҮД
(УС-6 орон, тоо хэмжээ)

БНСУ – Чили ЧХХ			БНСУ–Сингапур ЧХХ		
ГҮ–ийн шалгуур	Индекс	УС– 6 орон	ГҮ–ийн шалгуур	Индекс	УС– 6 орон
БТӨ+ҮБ	7	178	БТӨ+ҮП	7	292
БТӨ+ӨАШ	7	80	БТӨ+ӨАШ	7	144
БТӨ	6	1287	БТӨ	6	874
БТӨ эсхүл (БТӨ+ӨАШ)	6	1	БТӨ эсхүл (ЗТӨ+ӨАШ)	6	5
БТӨ эсхүл (ЗТӨ + ӨАШ)	6	27	ЗТӨ+ӨАШ	5	278
БТӨ эсхүл (МТӨ+ ӨАШ)	6	31	ЗТӨ	4	2968
ЗТӨ + ӨАШ	5	322	ЗТӨ эсхүл ӨАШ	4	1
ЗТӨ	4	1739	ЗТӨ эсхүл (ЗТӨ+ӨАШ)	4	85
ЗТӨ эсхүл (ЗТӨ+ӨАШ)	4	66	ЗТӨ эсхүл МТӨ+ӨАШ)	4	397
ЗТӨ эсхүл (МТӨ+ӨАШ)	4	471	МТӨ+ӨАШ	3	19
ЗТӨ эсхүл ӨАШ	4	739	МТӨ	2	117
МТӨ + ӨАШ	4	131	МТӨ эсхүл ӨАШ	2	1
МТӨ	3	105	ӨАШ	1	31
МТӨ эсхүл ӨАШ	3	5			
ӨАШ	1	30			
Нийт		5212			5212

Тэмдэглэгээ:

БТӨ – Бүлгийн түвшний өөрчлөлт (CC – Changes in 2 digit)

ЭТӨ – Зүйлийн түвшний өөрчлөлт (CTH – Changes in 4 digit)

МТӨ – Мөрийн түвшний өөрчлөлт (CTSH – Changes in 6 digit)

ҮБ – Үйлдвэрлэлийн буюу боловсруулалтын тодорхой технологи ашигласан байх (Specific production requirement)

ӨАШ – Өртгийн агууламжийн шаардлага (Regional value content)

Бүс нутгийн хэлэлцээрүүдэд нэмэлт шалгууруудыг мөрддөг хэмээн өмнө нь тэмдэглэсэн. Түгээмэл хэрэглэгддэг шалгуурууд нь үл тооцох хувь, нийлмэл гарал үүслийн шалгуур, гуравдагч оронд үйлдвэрлэх процесс болон тээвэрлэлтийн шалгуур зэрэг болно. БНСУ–ын Чили, Сингапурын хэлэлцээрийн жишээнээс үзэхэд үл тооцох хувь болон нийлмэл ГҮД-ийг аль алинийг нь мөрдөж байгаа ч 8% болон 10% гэсэн ялгаатай байдлаар тохирсон байна. Мөн гуравдагч оронд үйлдвэрлэх процессийн хувьд байгуулсан нийт хэлэлцээрүүдэд харилцан адилгүй тохиролцсон байна.

Хүснэгт 8. ГҮД–ийн нэмэлт шалгуур: БНСУ–ын хэлэлцээрүүд

Хэлэлцээр	Үл тооцох хувь	Нэмэлт шалгуур	
		Нийлмэл ГҮД	3–дагч оронд үйлдвэрлэх
БНСУ – Чили	8%	2 талт	
БНСУ– Сингапур	10%	2 талт	*
БНСУ – ASEAN**	10% (f.o.b); 10% (жингээс)	●	*
БНСУ – Колумб**	10% (f.o.b); 10% (жингээс)	●	
БНСУ – Перу**	10% 10% (жингээс)	●	* ¹⁰
БНСУ – ЕХ	%	●	
БНСУ – АНУ	%	●	
Япон – Сингапур	Байхгүй	2 талт	
Япон – Мексик	10%	2 талт	
АНУ – Сингапур	10%, 7% (жингээс)*	●	
ЕХ – Мексик	10% (exw)	2 талт	

¹⁰ Annex B – Exemption from the principle of territoriality “In determining the originating status of a good included in this Annex, operations and processes performed in the Gaecheon Industrial Complex located in North Korea, on materials exported there from Korea and subsequently re–imported to Korea, shall be considered to have been performed in the territory of Korea, provided that the total value of non–originating input does not exceed 40 percent of the FOB price of the good”.

НАФТА, ХАЧХХ	7% (f.o.b)	●	
ЕЧХХ	10% (exw)	●	*
ЕЧХХ – Сингапур	10% (exw)	●	*

Тайлбар: *АНУ– Сингапурын хэлэлцээрт үнийн дүнгээс 10%, утас, даавууны жингийн 7%–иар тохирсон.

** 50–63 дугаар бүлгийн бараанд хамаарна. ● – нийлмэл гарал үүсэл мөрдөгддөг, * – зөвшөөрсөн.

Судлаач Estevadeordal & Suominen (2004) нар Европ болон Америкийн 12 чөлөөт худалдааны хэлэлцээрийн гарал үүслийн дүрмийн хатуу байдлын (хязгаарлалтын) талаар харьцуулан судалсан байна. Судалгааны үр дүнд ПанЕвро гарал үүслийн дүрэм 4.5 хувьтай байсан бол ХАЧХХ (НАФТА)–ийн гарал үүслийн дүрмийн хязгаарлалт 5.1 хувьтай буюу илүү хатуу дүрмүүд үйлчилж байна гэсэн тооцоо гарчээ. Cheong & Cho (2009)¹¹–ийн БНСУ–ын 39 аж ахуйн нэгжийг хамруулсан судалгаанд тус улсын байгуулсан хэлэлцээрүүдийн гарал үүслийн дүрмийн талаарх ойлголтыг судалсан бөгөөд дийлэнх хувь нь БНСУ–ын хэлэлцээрт заасан гарал үүслийн дүрэм нь хатуу бөгөөд мөрдөхөд ээдрээтэй гэсэн дүгнэлтэд хүрч, ирээдүйд илүү уян хатан, дундаж хязгаарлалттай дүрмүүд мөрдөхийг санал болгожээ.

Дараах хүснэгтэд судлаач Estevadeordal (2003)–ийн бүтээлд үндэслэн БНСУ–ын бусад улстай байгуулсан хэлэлцээрийн гарал үүслийн дүрмийн хязгаарлалтыг Kim & Cho (2010) нарын эрдэмтэд нэгтгэсэн байна. БНСУ–ын байгуулсан хэлэлцээрүүдэд дийлэнх барааны хувьд гол төлөв индекс 4 түвшний гарал үүслийн дүрэм мөрдөгддөг бөгөөд Estevadeordal (2003)–ийн дүгнэснээр гарал үүслийн 2–оос дээш шалгуур мөрдөгдөж эхлэхэд дүрэм нь өөрөө хатуу хязгаарлалттай, чанга болдгийг онцолжээ. БНСУ–ын Чили, Сингапур, ЕФТА, АСЕАН–тай байгуулсан хэлэлцээрт нийт 61 төрлийн ГҮД мөрдөгдөж байна.

Хүснэгт 9. БНСУ–ын бусад улстай байгуулсан хэлэлцээрүүдийн
ГҮД болон хязгаарлалтын индекс

Индекс	Гарал үүслийн шалгуурын төрөл
1	---
2	CS; CS or RVS; CS+ECTC
3	CS*+RVC ; CS+ECTC or CS+RVC* ; CS+ECTC+RVC CS+RVC

¹¹ Cheong and Cho (2009). The Impact of Free Trade Agreements (FTAs) on Business in the Republic of Korea, ADBI Working Paper, No. 156, ASEAN Development Bank Institute (ADBI), Tokyo

4	CH ; CH or CS*+RVC ; CH or CS+ECTC+RVC CH or CS+RVC ; CH or CS+TECH ; CH or RVC CH or RVC* ; CH or RVC+TECH CH or TECH or RVC ; CH+ECTC ; CH+ECTC or CS* CH+ECTC or CS* or CS*+RVC ; CH+ECTC or RVC CH+ECTC or TECH; CS* or CH or RVC RVC(>40%)
5	CH or CH*+RVC; CH+ECTC or CH*+RVC CH+ECTC or CH+RVC; CH+RVC CH+RVC or CS*+RVC; CH+RVC or RVC RVC(>40%)
6	CC ; CC or CH* ; CC or CH*/CS*+RVC CC or CH*+RVC ; CC or CH+RVC; CC or CS* CC or CS*+RVC ; CC or CS+RVC ; CC or RVC CC or RVC+TECH; CC or TECH ; CC+ECTC CC+ECTC or CH*+RVC ; CC+ECTC or CS*
7	CC+ECTC+RM ; CC+ECTC+TECH; CC+ECTC+TECH or CS*+TECH ; CC+RM CC+RM or RVC+RM; CC+RM+TECH or RVC CC+RVC; CC+TECH ; CC+TECH or RVC CC+TECH or RVC+TECHCH+RM; CH+RM or RVC CH+RM or RVC+RM; RM ; RVC+RM ; WO

Эх сурвалж: Kim & Cho. (2010); БНСУ–Чили, БНСУ–Сингапур, БНСУ–ЕФТА, БНСУ–АСЕАН–ы хэлэлцээрийг авч үзсэн.

ХАЧХХ (NAFTA)–ийн гарал үүслийн дүрэм нь олон чөлөөт худалдааны хэлэлцээрийн суурь болдог бөгөөд Канад, Чили, Мексик, Япон, БНСУ зэрэг улсуудын хэлэлцээрийн гарал үүслийн дүрэмд тусгалаа олжээ. Энэхүү аргачлалд үндсэн хоёр төрлийн арга буюу хэлцлийн үнийн арга (transaction value method) болон нийт өртөг тооцох арга (net cost method) мөрдөгдөж байгааг өмнө дурдсан.

Харин нөгөө талаас ЕХ–ны гарал үүслийн дүрэм нь ПанЕвро дүрэмд суурилсан байх бөгөөд ЕХ–ны хэлэлцээрүүд болох ЕХ–ЕФТА–гийн хэлэлцээр, ЕХ–Мексикийн хэлэлцээр зэрэгт маш нийтлэг хэм хэмжээтэйгээр мөрдөж байна. Ерөнхийдөө ЕХ–ны гарал үүслийн дүрмийг харьцангуй хатуу гэж үздэг¹². ЕХ–ны гарал үүслийн дүрэм голдуу зүйлийн түвшний өөрчлөлтийн шалгуурт суурилсан байдаг ба ӨАШ дүрмийг 20%–иас 50%–тай байхаар тохирдог. УС–ийн 30 дугаар бүлгийн хувьд ӨАШ нь 20%–тай байна. ЕХ–ны гарал үүслийн дүрмийн нэг асуудалтай тал нь экспортлогчдод эргэлзээтэй олон дүрмийг тусгасан байна. Тухайлбал, УС–ийн 18–22 дугаар бүлгийн сахар, какао гэсэн бараанд тусгай шалгууруудыг тавьдаг ажээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

БНСУ–тай Монгол Улс ЭЗТХ байгуулахаар талууд удаа дараа уулзаж, ажлын хэсэг байгуулагдан хамтарсан судалгааг хийсээр ирсэн билээ. Монгол

¹² Cheong and Cho (2009).

Улс тус улстай эдийн засаг, улс төр, нийгэм, соёл боловсролын салбарт харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн нь сайшаалтай. БНСУ-тай худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагааг улам нэмэгдүүлж, хөхиүлэн дэмжих гол арга зам нь Талууд ЭЗТХ байгуулах явдал гэж үзэж байна.

Тус судалгаанд БНСУ-тай хэлэлцээр байгуулахад ГҮД-ийн анхаарах гол асуудлуудыг судалсан. Ингэхдээ экспортын боломжит бүтээгдэхүүний ГҮД, дотоодын эмзэг барааны болон салбарын ГҮД мөн шилдэг туршлагын талаар харьцуулан судлаж шинжилгээ хийсний үндсэн дээр дараах саналыг гаргалаа. Үүнд: БНСУ-тай хэлэлцээр хийхэд аль болох хатуу ГҮД тохирохгүй байх, хатуу дүрмийн тохироо гэж юу болохыг судлах (судалгаанд дурьдсан), ПанЕвро болон НАФТА-гийн дүрмийн хэрэглээг сайн ойлгох; БНСУ-ын хувьд түнш улсуудтай байгуулсан хэлэлцээрт тарифын ангилал өөрчлөгдөх дүрмийг дангаар болон ӨАШ-тай хослуулсан.

Энэ нь хэт нэг талыг барихгүй, боломжит хувилбарыг сонгох боломж үүсгэнэ; Эмзэг салбарын хувьд түнш орнууд процессийн шалгуур болон БТӨ шаардлагыг ӨАШ-тай цуг хэрэглэх хувилбар оруулсан. Тиймээс манай тал өөрсдийн орны дотоодын үйлдвэрлэлийн онцлог, цаашдын чиг хандлагыг тодорхойлон ГҮД-ээ тохирох; хэлэлцээр байгуулахдаа үл тооцох хувийг жингийн 10-иар мөрдөх эсхүл үнийн дүнгийн 10% -иар тохирох эсэхээ тухайн бараа, салбараа судлаж шийдэх; ГҮД-ийг тохирохдоо анхнаасаа гарал үүслийн процесст бий захиргааны шинж чанартай чирэгдлийг арилгах тал дээр анхааран ажиллах; ГҮД-ийн тохироо болон хэлэлцээрийн хэрэгжилт, ашиглалт хоорондоо нягт уялдаатайг судалгаанууд харуулсан. Тиймээс дүрмийн ойлголтыг бизнес эрхлэлчдэд гүнзгий ойлгуулах, улмаар хэлэлцээрийн хэрэгжилт, ашиглалтыг нэмэгдүүлэх асуудалд анхаарах нь зүйтэй; ГҮД нь худалдаан дахь тарифын бус хориг саад гэж тооцогддог бөгөөд үүний баялагт үзүүлэх бодит сөрөг нөлөөллийг тооцоход төвөгтэй байдаг.

Мэдээж ГҮД нь худалдааны хэлэлцээрүүдэд зайлшгүй шаардлагатай ч гэсэн хэлэлцээрт хэрхэн нарийвчлан, хатуу тохирсноос хамаараад худалдааг хязгаарлах, хөрөнгө оруулалтыг сааруулах, бүтээмжийн өсөлтийг удаашруулах, баялагийг бууруулах зэрэг сөрөг нөлөөллийг авчирдаг. Мөн бизнес эрхлэхэд байгууллагуудад үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлж, гаалийн байгууллагуудын хувьд гарал үүслийн аудитийн зардлыг нэмэгдүүлдэг гэж судлаачид үзжээ¹³. Үүнийг хэлэлцээ хийхдээ харгалзах нь зүйтэй.

Мөн экспортлогчдод практик заавар боловсруулж гарын авлага болгох. Тухайлбал, 2021 онд “EU–Korea FTA Practical Guide for European Exporters”, мөн EU–South Korea Free Trade Agreement: A Quick Reading Guide зэргийг

13 Krueger (1993), Krishna and Krueger (1995b), Vermulst et al. (1994), Hoekman (1993), Estevadeordal (1999) and Brenton (2003).

боловсруулсан байна. Эндээс үндсэн санааг авч ижил төстэй заавар, зөвлөмж экспортлогчдод зориулан боловсруулах шаардлагатай. Цаашлаад дэлхийн улс орнууд хэлэлцээрийн ашиглалтын талаарх судалгааг тогтмол хийдэг бөгөөд үүнд эзлэх гол саадад тарифын бус зохицуулалт, ГҮД багтдаг. Тиймээс хэлэлцээрийн ашиглалт, үр дүнд сөргөөр нөлөөлөх гарал үүслийн шалгуураас зайлсхийх нь зүйтэй гэсэн саналтай байна.

Ашигласан материал:

- Bhagwati, J & Panagariya, A 1996, 'The theory of preferential trade agreements: historical evolution and current trends', *American Economic Review*, vol. 86, no. 2, pp. 82–7.
- Brenton, P & Imagawa, H 2005, 'Rules of origin, trade, and Customs' in L de Wulf & JB Sokol (eds), *Customs modernization handbook*, World Bank, Washington, DC, pp. 183–214.
- Estevadeordal, A. (2000). Negotiating preferential market access: The case of the North American Free Trade Agreement. *Journal of World Trade*, 34(1), 141–166.
- Estevadeordal, A & Suominen, K 2004, 'Rules of origin: a world map and trade effects', in O Cadot, A Estevadeordal, A Suwa–Eisenmann & T Verdier (eds), *The origin of goods: a conceptual and empirical assessment of rules of origin in Preferential Trade Agreements*, IADB and CEPR, Washington, DC, pp. 1214–45.
- Cho, J., and I. Cheong. 2008. Survey on Korean Companies on the Utilization of FTAs. Presented at the seminar by Korea Association of International Trade and Industries, Suwon, 28 November. Korean
- Cho, J., and I. Cheong. 2009. The Impact of Free Trade Agreements (FTAs) on Business in the Republic of Korea. ADB Institute Working papers. No.156 (October). Tokyo: ADBI.
- Falvey, R & Reed, G 1998, 'Economic effects of rules of origin', *Weltwirtschaftliches Archiv*, vol. 134, no. 2, pp. 209–29.
- Izam, M 2003, *Rules of origin and trade facilitation in preferential trade agreements in Latin America*, vol. 31, United Nations Economic Commission for Latin America and the Caribbean, Santiago.

- Ju, J & Krishna, K 1998, 'Firm behavior and market access in a free trade area with rules of origin', National Bureau of Economic Research Working Paper No. 6857.
- Krishna, K. (2006), "Understanding Rules of Origin," in *The Origin of Goods: Rules of Origin in Free-Trade Agreements*, ed. by O. Cadot, A. Estevadeordal, A. S. Eisenmann, and T. Verdier, pp. 19–34. Oxford University Press.
- Krishna, K., and J. Ju (2005), "Firm Behaviour and Market Access in a Free Trade Area with Rules of Origin," *Canadian Journal of Economics*, 38(1), 290–308.
- Krishna, K., and A. Krueger (1995), "Implementing Free Trade Areas: Rules of Origin and Hidden Protection," NBER Working Papers 4983, National Bureau of Economic Research.
- Krueger, A. (1993), "Free Trade Agreements as Protectionist Devices: Rules of Origin," NBER Working Papers 4352, National Bureau of Economic Research.
- LaNasa III, JA 1993, 'Rules of origin under the North American free trade agreement: a substantial transformation into objectively transparent protectionism', *Harvard International Law Journal*, vol. 34, no. 2, p. 381.
- Lloyd, PJ 1993, 'A tariff substitute for rules of origin in free trade areas', *World Economy*, vol. 16, no. 6, pp. 699–712.
- Manchin, M & Pelkmans–Balaoing, A 2007a, 'Clothes without an emperor: analysis of the preferential tariffs in ASEAN', *Journal of Asian Economics*, vol. 19, no. 3, pp. 213–23.
- Manchin, M & Pelkmans–Balaoing, A 2007b, 'Rules of origin and the web of East Asian free trade agreements', World Bank Policy Research Working Paper No. 4273, July, World Bank, Washington, DC
- RosellYn (2000) The economics of rules of origin, *The Journal of International Trade & Economic Development*, 9:4, 397–425,
- Vermulst, EA 1992, 'Rules of origin as commercial policy instruments: revisited', *Journal of World Trade*, vol. 26, no. 6, pp. 61–102.